



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/7292

Улаанбаатар хот

Барилга байгууламж нийслэлийн  
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 111 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан нийт 1,451,848,860.00 (нэг тэрбум дөрвөн зуун тавин нэгэн сая найман зуун дөчин найман мянга найман зуун жар) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад заасан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдэж байгаа барилгыг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэг (Г.Танхил)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205591

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
...<sup>11</sup> дугаар сарын <sup>04</sup>...ны өдрийн  
*№12292 дугаар* захирамжийн  
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэгийн барилга	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 7 хороолол /14182/, Алтайн гудамж 263 тоот	2024	2024	1,451,848,860.00	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
Нийслэлийн өмчид бүртгэх барилгын нийт дүн					1,451,848,860.00	